

## **Н.Золжаргал: “Рио Тинто”-гийн 20 хувийг “Чалко” эзэмшдэг юм билээ**

А.АРИУНБОЛД

*“Эдийн засгийн аюулгүй байдал” сэдэвт семинар өчигдөр боллоо. Үнэндээ энэ сэдэв бараг мартагдах шахсан энэ үед уг семинар ангасан цэцгийг услах мэт хэрэгцээтэй байсныг оролцогчид онцолсон юм. Семинарыг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо болон “Конрад-Аденауэр” сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан байна. Энэ үеэр Монголбанкны дэд ерөнхийлөгч Н.Золжаргалтай уулзаж манай эдийн засгийн аюулгүй байдлын талаар ярилцлаа.*

### **-Таны бодлоор эдийн засгийн аюулгүй байдлыг хэрхэн хангах вэ?**

Монголын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт нь эдийн засгийн аюулгүй байдлыг урт хугацаанд хангах үндсэн шалгуур гэдэгтэй олон эдийн засагч санал нэг байгаа биз. Эдийн засгийн тогтвортой өсөлт нь манай эдийн засгийн аюулгүй байдлын үндсэн илэрхийлэл нь юм.

### **-Үндэсний баячууд нь нийгмээ чирдэг гэх ойлголт байдаг шүү дээ?**

-Дэлхийн эдийн засгийн хандлагаас харахад дундаж орлоготой иргэд нь эдийн засгийн гол суурь болох ёстой. Гэтэл Монголд эдийн засгийн суурь нь бага орлоготой иргэд болчихоод байна шүү дээ. Дундаж орлоготой иргэд нь цөөрөөд, өндөр орлоготой иргэд нь Монголын нийт хөрөнгө активийн дийлэнхийг эзэмшиж байгаа ийм дүр зураг харагдаж байгаа юм. Үүнийг эрсдэл гэдгийг Африкийн орнууд маш тодорхой харуулсан шүү дээ. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Африкийн тав зургаахан орноос 80 тэрбум ам.доллар нь урсаад гарчихсан. Улс төр, нийгмийн тогтворгүй байдал нь хөрөнгийн гадагшлах урсгалыг нэмдэг учраас бид өндөр орлоготой иргэдээрээ эдийн засгаа чирнэ гэж төсөөлж байгаа бол хамгийн буруу төсөөлөл. Харин ч энэ нь эрсдлийг шууд авчирч байгаа хэрэг.

### **-Хэрэв дундаж орлоготой иргэд олширч, орлого нь нэмэгдвэл юу болно гэсэн үг вэ?**

-Хэрэв дундаж давхарга хүчтэй байх юм бол зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хууль үйлчилж, жирийн эдийн засаг болдог. Гэтэл манайд энэ хууль бараг үйлчилдэггүй. Учир нь дундаж давхарга нь дэндүү цөөн. Тиймээс зах зээлийн эдийн засгийн хуулиуд нь үйлчлэхгүй болоод эхэлж байгаа юм. Тоон үзүүлэлтээр бол дундаж давхаргын ху-римтлал буюу хадгаламж нь 3.7 дахин, Нийгмийн даатгалын сангийн орлого буюу ирээдүйн тэтгэвэртээ хэрэглэх мөнгө нь 3.6 дахин өсчихсөн харагдаад байгаа. Гэвч үүнийг задлахаар тэс ондоо дүр зураг харагдана. Уг нь манай банк санхүүгийн гол үйлчлүүлэгч, суурь нь дундаж орлоготой иргэд болж байж эдийн засаг нь тогтвортой байх юм. Дундаж давхарга буюу нийгмийн 60 хувь нь тогтвортой бол энэ нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгодог гэдэгт олон эдийн засагч итгэдэг. Эдийн засгийн тогтвортой өсөлт, дундаж давхаргын өсөлт нь шууд хамааралтай юм. Азийн түвшинд харвал өдрийн хоёр доллар болон түүнээс бага орлоготой иргэдийг нийгмийн доод давхарга гэж үзээд судалгаа хийхэд сүүлийн жилүүдэд дээрх иргэдийн тоо цөөрч 2-20 ам.долларын орлоготой иргэдийн тоо нэмэгдсэн байгаа. Гэтэл Монголын бага орлоготой иргэдийн тоо нь нийгэмдээ нэлээд өндөр хувь эзэлдэг. Харин бидний хүсээд, зориод байгаа жишиг болох улс орнуудын нэг Германыг харвал тэнд өдрийн зургаан ам.долларын орлоготой иргэн бараг үгүй. Тэнд өдрийн 20-иос дээш ам.долларын орлоготой иргэд нь дундажид тооцогддог. Гэтэл бид тэр дундажид хүрэхэд нэлээд хол байна.

### **-Манай улсын хувьд дундаж орлоготой иргэд нь хэр олон бол?**

-Улс орнуудын дундаж орлоготой иргэдийн тоог олохдоо моргейжийн зээлээр хэмждэг. Манай улсын хэмжээнд моргейжийн зээлтэй хүн өнгөр-сөн жилүүдэд 17 мянгаас 26 мянга болсон байгаа юм. Гэхдээ энэ өсөлтийг хуваагаад үзвэл 4000 нь төрийн албан хаагчид. Харин орлого нь нэмэгдээгүй байхад орон сууцны үнэ өсч буй нөхцөлд худалдан авч буй үлдсэн 5000 нь өндөр орлоготнууд бололтой. Ингээд нийт хүн амд

хуваагаад үзвэл бид нийт зээлийнхээ 25 хувийг л орон сууцанд зориулаад байгаа мэт. Ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл манай улсын хэмжээнд 700 орчим тэрбум төгрөг болж, зээлдэгчийн тоо 1300-гаар өссөн байгаа юм. Орон сууцны үнийн өсөлт нь дундаж давхаргад сөргөөр нөлөөлдөг юм байна. Дундаж давхаргынхан орон сууц худалдаж авах босгод дөхөхгүй байна шүү дээ. Учир нь үнэ нь өсөөд байхад орлого нь нэмэгдэхгүй байгаа юм. Нийт моргейжээ ДНБ-тэй харьцуулахаар манайх дөнгөж зургаан хувьтай байдаг. Япон, Герман, Сингапуртай бол ярих юм байхгүй. АНУ хаана очиж дампуурсан бэ гэхээр 70 хувьд хүрсэн хойно дампуурчээ. Тэгэхээр бид энэ харьцаагаа ядаж БНСУ-ынх руу дөхүүлэх хэрэгтэй шиг байгаа юм. Дундаж давхаргынхан их хэмжээгээр моргейжийн зээл авч байж эдийн засаг тогтворждог бололтой.

**-Дундаж орлоготой иргэ-дийн тоо олширч чадахгүй байгаагийн шалтгааныг та юу гэж харж байна?**

-715 мянган өрхийн дундаж хадгаламж нь 20.5 сая төгрөг, 27 мянган өрхийнх 57 сая төгрөг. Нийтээр нь үзвэл 22 дахин зөрүүтэй байгаа юм. Энэ нь банк санхүүгийн өсөлт дундаж давхаргадаа бус өндөр орлоготнуудад л наалдаад байгааг харуулна. Үндсэндээ манай дундаж орлоготой иргэдийн тоо олширч чадахгүй байна гэдгийг л хэлээд байгаа юм. Дээрээс нь үнийн дарамт харьцангуй их. Тухайлбал, инфляци 17 хувьтай, хүнсний үнийн өсөлт 28 хувьтай байхад яг үнэндээ бол дундаж давхаргынханд 20-30 хувийн дарамт үүсгэдэг. Нэн ядуу иргэдийн зарлагын 80 хувь нь хүнс байдаг учраас тэдэнд 50-60 хувийн дарамт болдог бол өндөр орлоготой иргэдийн хувьд бараг нөлөө байхгүй. Тэдэнд хүнсний үнэ бус зээлийн хүү л чухал. Тиймээс Монголбанк бодлогын хүүгээ өсгөдөг, үүнээс болж өндөр орлоготнуудтай л “хэрүүл” хийж байдаг юм шүү дээ. Дундаж давхаргагүй болж байгаа нь манай улсын томоохон эрсдэл. Бид энэ давхаргаа өөрсдөө нураагаад байгаа юм. Түүнээс гадныхан үүнд огт хамаагүй шүү дээ.

**-Манай төр засгийн зүгээс дундаж давхаргынхныг олш-руулахын тулд уул уурхайн салбарыг ашиглана гэсэн байр суурьтай байдаг шүү дээ?**

-Манай ДНБ, эдийн засгийн 17 хувийн өсөлтийнх нь хоёр-хон хувь нь уул уурхайн салбар гэсэн статистик гараад байгаа юм. Бодит байдал дээр бол Монголын эдийн засгийн өсөлтийн дийлэнх хувь нь уул уурхайнх байх. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 85 хувь нь уул уурхайн салбарт орсон нь дээрхийг батлаад байгаа. Түүнчлэн манай экс-портын бүтээгдэхүүний үнийн дүнгийн 95 хувь нь уул уурхайн бүтээгдэхүүн. 2006 онд энэ тоо 75 хувь байсан шүү дээ. Уул уурхайгаас хамаарч буй байдал нь үүнээс цааш явна гэж байдаггүй байлгүй дээ. Гэтэл төгрөгийн ханшаа харвал чангараад байна. Энэ нь уул уур-хайн хөрөнгө оруулалт төгрөгийн ханшийг чангалаад байна гэсэн үг. Үүний үр дүнд уул уурхайгаас бусад салбар нь хөгждөггүй, экспортод үү-нээс өөр салбарын бүтээгдэ-хүүн нэмэгддэггүй. Төгрөгийн ханш чанга учир зүгээр импортолчихсон нь хамаагүй амар болчихдог. Уул уурхайгаас хамаарах хамааралтай зэрэгцээд нийгмийн халамжаа нэмээд л байсан. 2006 онд 100 хүрэхгүй тэрбумыг халамжинд зарцуулж байсан бол 2011 онд 900 тэрбумыг төсөвлөсөн. Хоёр жилийнх нь тоог нэмээд үзэх юм бол Оюутолгойг тэр чигээр нь халамжиндаа зарцуулчихсан сууж байгаа.

**-Гэхдээ ядуурал буурч 29 хувьтай болсон гэсэн тооцоо өнгөрсөн долоо хоногт гарсан байна билээ?**

-Бид 41 хувь болов уу гэж таамаглаж байсан. Эцсийн дүн-дээ ямар ялгаатай юм бэ. Нийт хүн амын гуравны нэг нь ядуу байна шүү дээ. Гэтэл өнөө уул уурхай маань ажлын байр бий болгоод ажиллах хүчнийг нэмэгдүүлээд байна уу гэхээр бас тийм биш ээ. 2008 онд 18 мянган хүн энэ салбарт ажиллаж байсан бол өдгөө 34 мянга болсон. Сайхан байна. Гэхдээ уул уурхайн салбарт ажлын байр бий болгож үүгээрээ цаашдаа бид явна гэж бодож байгаа бол үүн шиг том эндүүрэл үгүй. Ингээд эргээд харахаар угаасаа “голланд өвчин” манайд хүрээгээ тэлснийг харуулж буй.

**-Манай эдийн засаг сүүл-дээ дан ганц зах зээлээс хамааралтай, дээсэн дөрөөн дээр байгаа гэж та хэлэх гээд байгаа юм аа даа?**

-Угаасаа уул уурхай нь тухайн эдийн засгаа нэг сал-бараас, нэг зах зээлээс хараат болгодог. Сүүлдээ бүр нэг компаниас хараат болгодог болсон байна шүү дээ. Одоо “Чайна Алюминиум” буюу “Чалко” гэж “од” болсон ком-пани байна. Сонирхолтой нь “Чалко” компани нь “Рио Тинто”-гийн 20 хувийг эзэмшдэг шүү дээ. Хоёрхон

жилийн өмнө “Рио Тинто”-г худалдаж авъя гэж тендер зарласан компани нь “Чалко” юм. Хятадын хөрөнгө оруулалттай, Хонконгийн биржид бүртгэлтэй компаниудын цаана ганцхан компани байдаг. Энэ нь урд хөршийн Засгийн газрын 100 хувийн эзэмшилтэй “Хятадын хөрөнгө оруулалтын корпораци”. Тэгэхээр энэ уул уурхайгаас болоод ганц компаниас хамаарах эдийн засгийн хамаарал нь эрс нэмэгдчихэж байгаа юм. Ингээд уул уурхайгаас өөр бизнес нь эдийн засгаасаа шахагдаж үүнийгээ дагаад дундаж давхаргынхан ч шахаг-дана гэсэн үг. Эцэст нь дүгнэхэд уул уурхай бол бидний хүсээд байгаа дундаж давхаргад эергээр нөлөөлөх эд биш болж таарах нь.